



МОНГОЛ ҮСГИЙН ЗУРЛАГА ХЭЛБЭРИЙГ ЗАГВАРЧЛАН СЭРГЭЭХ АРГА

(Өвөр Монголын Аржай агуйн бичээсийн жишээн дээр)

Б.Тала

МУИС-ийн Түүхийн Тэнхимийн докторант

Abstract: Graphic repair of Mongolian characters is a new direction in the field of philology research. The inscription of “The Praises of the Seventh Tara Subduer of Black Magic” in Arjai Grotto 32 of Ordos, Inner Mongolia has been preserved comparatively intact. Now 10 letters have been preserved intact (including particles), 11 letters have been blurred and 3 letters have been completely broken in this inscription. These letters are broken up into 107 syllables and have been analyzed in this paper. We have reached to a satisfactory result in repairing 9 broken or blurred letters.

Түлхүүр үг: зурлага, баримжаа зурлага, Аржайн агуй, загварчлан сэргээх арга, монгол үсэг

Хуучин ном судар нь Монголчуудын уугуул соёлын өв байж, эдгээр өв соёлоо хэрхэн хадгалж хамгаалан өвлөн залгамжлах нь бидний үеийн тулгамдсан асуудлын нэг юм. Хуучин ном судрын уламжлалт засан сэргээлтийн ажил нь хэл шинжлэл, түүхийн ухааны судалгааны зайлшгүй анхааралдаа авах асуудал билээ.

Монгол үсгийн хэлбэр — зурлагад загварчлан судалгаа хийх нь хуучин ном судрын уг эхийг эвдэхгүйгээр балархайшсан үсгийг баримт үндэслэлтэйгээр үсгийн зурлага хэлбэрийн хэв маяг, онцлогийн дагуу нөхөн сэргээж, үнэтэй хэрэглэгдэхүүн болгон үлдээх явдал юм.

Аржай агуй нь Өвөр Монголын Ордос хотын баруун хойно байгаа Арвис сумын хязгаарт оршдог. Умарт өргөрөгийн 39,7 градус, зүүн уртрагийн 107,3 градуст

байрших их цөлийн өмнөх Монгол нутагт эдүгээ хүртэл мэдэгдсэн хамгийн том хэмжээний агуйн барилгын үлдэц юм (Хасэрдэнэ, Данзан, Бүрэнбат, Гарьд, Жалсан, Батжаргал, Энхбаатар 1997, т.1). Аржай агуй бол 80 метр өндөр, зүүнээс баруун тийш 300 шахам метр урт, тэгш оройтой, урт дөрвөлжин хэлбэртэй, хадат уул билээ (Хас-Эрдэнэ ба бус, 1997.т.2). Аржайг тойрсон хаданд их, бага малтмал дөрвөлжин агуйнууд бий. Агуйн дотор ханыг буудайн сүрэлтэй хольсон нялтаг (улаан шаргал) шавраар тэгш сайхан өнгөлөн цайлгаад, хана бүрийг дүүртэл дөрвөлжлөн хувааж, дөрвөлж бүрт нэг нэг бурхан, Архун, Дарь эхийн хөргийг дүрсэлжээ.

Дөрвөлжүүдийн хоорондох зайг цагаан, ногоон, улаан, саарал дөрвөн өнгөөр судал татуулан будаж, хөндлөн судалт нэг нэг мөр ланз буюу төвд үсэг, голдуу судал бүрт нэг, нэг мөр уйгаржин монгол бичгийн дүрслэлийг бэхээр хулсан үзгээр бичжээ.

Аржайн 32 дугаар агуйн хананд монгол үсэг /тус өгүүлэлд ярьж байгаа монгол үсэг нь уйгаржин монголыг зааж байна/-ийн бичээс байж, энэ нь одоо хүртэл олдож байгаа цорын ганц монгол, санскрит, төвд гурван үсгийг харгалзуулан бичсэн дүрслэл юм. Агуйн малтагдсан болон ханын бичээсийг бичсэн он цагийн талаар эрдэмтэд олон янзын саналтай байдаг.

Агуйн ханан бичээс нь он удсан ба орчин ахуйгаас шалтгаалан балархайшсан, эвдэгдсэн, сүйдсэн байдал нэлээд байна. Бүгд Найрамдах Хятад Ард Улс байгуулагдсаны дараагаар соёлын хувьсгалаас болж эвдэрч

балран бүтэн бичээс бараг үлдээгүй шахам байдаг.

Аржайн 32 дугаар агуйд үлдсэн бичээс нь “Хорин нэгэн Дарь эхийн магтаал”, “Арван зургаан архадын магтаал”, “Дүншаны гучин таван бурханы магтаалын шүлэг” зэрэг магтаал шүлэг нийт 83 байж, одоо үлдсэн 55 (Хас-Эрдэнэ ба бус, 1997) * байна. Миний бие Аржайн агуйд хоёр удаа хээрийн шинжилгээ хийснээр магтаал шүлэг нийт 46 ** бичээс бүхий 800 гаруй үсэгтэй байгааг тогтоосон.

Аржайн ханын бичээсийн тухай өмнөх эрдэмтдийн судалгаа нь үсгийн зурлага хэлбэрийг загварчлан сэргээх суурь үндэслэл болж өгч байна. Онцлон дурдууштай нь “Болор толь” ба “Дарь эхийн тайлбар” зэрэг номонд мэдээлснээр хамгийн анхны “Дарь эхийн магтаал”-ыг долдугаар зууны үеийн Энэтхэгийн их шидтэн Зандрагүм багш зохиосон гэдэг.

Дүрэмчлэн боловсруулсан уншлагын шүлгийг хэн, хэзээ зохиосон нь одоо болтол тодорхойгүй байна. Гэхдээ “Дарь эхийн магтаал”-ын хамгийн анхны орчуулгыг Мин улсын Шиүван Дегийн зургадугаар он /1431/-д Бээжинд барлажээ.

Энэ нь одоо Дамаркийн хааны ордонд хадгалагдаж байна. Аржай агуйн “Дарь эхийн магтаал”-тай үсэг бүр нь нэг нэгэнтэйгээ дүйдэг. Зөвхөн үсгийн цөөнх зурлага болон бичигдсэн зурлагын зөрөө байдаг болохоор сүйдсэн үсгийн зурлага хэлбэрийн загварчлан сэргээлтийн баримт үндэслэл болдог.

Аржайн 32 дугаар агуйн ханын бичээсийн монгол үсэгт загварчлан сэргээлт хийхдээ ханын бичээсийн монгол үсэгт системтэй цуглуулга хийж, дахин дижитал хэлбэрт оруулж, дараа нь дижитал хэлбэрийн үсэгт үсэглэвэрээр задлан зурлага, хэлбэрт нь анализ хийж, онцлогийг гарган тавих гэж оролдлоо. Хамгийн эцэст ханын бичээсийн монгол үсгийн балархайшсан буюу эвдэгдэж сүйдсэн хэсэгт загварчлан сэргээлт хийлээ.

1. Аржай агуйн 32 дугаар агуйн ханын бичээсийн монгол үсгийг гэрэл зургаар авч дижитал хэлбэрт орууллаа. Аржай агуйгаас олдсон 46 бадаг бичээсийг 46 багц болгон хувааж, ханын бичээсийн зургийг компьютерт суулган Adobe Illustrator-ээр 46 бадаг бичээсийн 800 гаруй үсгийг сийлж, дижитал хэлбэрт оруулан дараах байдлаар авч үзэв.

Дижитал хэлбэрийн үсгээ монгол хэл зүйн үе, авиагаар задлан салгаж, латин үсэг, араб тоогоор хадаж жагсааж /Зураг 1-а/ эдгээрээ ижил авиа буюу ижил зурлагаар хүснэгтлэн оруулав. Жишээлбэл, а-1/”а” авиаг зааж байна. “а” авиа эхэнд, дунд, адагт хэлбэрээр 17 бичигдсэн байна/ нь “а” үсэглэвэрийг нэгдүгээрт байршуулсан буй. /Зураг 1- б/.

Энэ нь ижил зурлага өөр үсэглэвэрт * анализ хийж онцлогийг нь хураангуйлахад илүү хялбар болгож үзүүлж байна. Задлан санагалзсан үсэглэвэрээ цагаан толгойд жагсааж тавихад нэг бадагт бичигдсэн авиа нь ил тодорхой харагдаж, загварчлан сэргээлтэд гол үндэслэл болно.

/Зураг 2/

* “Аржай агуйн уйгаржин монгол бичээсийн судлал” нь уг ном нь 1997 онд хэвлэгдсэнХятадын сурган хүмүүжлийн яамны эртний сурвалж бичгийн “Наян тав” төсөл, Өмнө хойно Аржай агуйд 5 удаа хээрийн шинжлэл хийж, 7 жилийн хугацаа хэрэгсэн туурвисан судлалын бүтээл юм.


** Миний бие 2009 оны 5 сар болон 2010 оны 10 сард Аржай агуйд хээрийн шинжлэл хийж, нийт 1400 орчим зураг авч, бүртгэн эмхтгэсэнээр 46 бадаг магтаал шүлэг оллоо.

* **Үсэглэвэр** гэдэг Европын хэл шинжээчний “графэм” хэмээх нэрийдэл Эрдэмтэн Ц.Норжин Д.Баатар нарын зохиолд дурдсан авиа бүрээр нэгчилсэн тэмдэг гэдэгтэй нь тохирно.

Зураг 1-а



Зураг 1-б



Зураг 2


no	01	02	03	04	05	06	07	08	09	10	11	12	13	14	15	16	17	18	19	20	21	22	23	24	
МОНГОЛ НЭВЭЛТ ЦАГААН ТОГЛОЛ ой	нөхө	▲	▲		●				●	●	●			●				●	●	▲	▲				
	дунд	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲	▲
	гялр	▲			●	●		▲	▲						●					▲				▲	
гялр	a	e	i	o	u	ö	ü	n	b	q	k	γ	g	m	l	s	š	t	d	j	č	y	r	ng	

2. Монгол үсгийн загварчлан сэргээх арга. Монгол үсгийн зурлагад нурууны зурлага нь үсэглэвэрийг холбох үйлдэл болж нурууны зурлагын хэлбэр нь уг үсгийн хэлбэрийн онцлог юм. Аржай агуйн ханан дахь үсгийг монгол үсэгт загварчлан сэргээлт хийхэд гурван баримжаат зурлага хэлбэрийн стандартыг тогтоох хэрэгтэй байдаг. Үүнд, өргөн, нарийн зурлага зэрэг хэлбэрийн хэд хэдэн стандарт хэрэглэдэг. Өргөн зурлагын хэлбэрийн стандарт нь зурлагын давхцалын хэсэг /Зураг 3- т а- гаар үзүүлэв/- ийн зохих хэмжээг зааж, баримжаа зургийн хэлбэрийн стандарт нь нурууны зурлага хэлбэрийн байнга илрэх тэр хэмжээгээр баримжаалсан байдаг. Хулсан үзгээр бичихэд хулсан үзгийн хирийг* налуу өнцөг хавчиж барих бичлэгийн журмыг баримталдаг. /Зураг 3-т b-гээр үзүүлэв/. Нарийн зурлагын хэлбэрийн стандарт нь даруй хулсан үзгийн хирийг хөндлөн чиглэлээр бичигдэх зурлагын хэлбэрийн стандарт хэмжээ болно. /Зураг 3-т c-гээр үзүүлэв/.

**Хир гэдэг хулсан үзгийн үзүүрийн хавтгай хэсгийг хэлнэ

Үсэглэвэрт анализ хийхэд баримжаа зурлагын хэлбэрийн 1/2-оор шугамчилж үсэглэвэрийн урт, өргөн, өнцөг хавчилтад анализ хийсэн болно /Зураг 5-b/. Үүнд стандартын диаметрээр тойрог зурж, энэхүү тойргоо 30 градусаар хуваарилан, түвшинтэй* нь хавчсан өнцгийг барагцаалан тогтоодог байна. /Зураг 5-a/.

Зураг 3



Зураг 4



3. Аржайн агуйн 32 дугаар агуй дахь “Долдугаар Дарь эх чанадасыг тэмцэгчийг эвдэгчийн магтаал”-ын ханын бичээсийн загварчлан сэргээв.

“Чанадсыг тэмцэгчийг эвдэгч” хэмээх бол “Хорин нэгэн Дарь эх”-ийн долдугаар суудалд саатагч байсан аж. Түүний лагшин дүрийн дүрслэлийг үзвээс, чанадасыг тэмцэгчийг эвдэгч Дарь эх нь шар бадам цэцэг ба Шарбур үсээ дээш сэргийлгэсэн, хар өнгөтэй нэгэн нүүртэй, дөрвөн гартай, баруун анхны гараар хүрд, нөгөө гараар илд, зүүн талын анхны гараар төрлийн орон дээр сэлэм, нөгөө гараар занархуй мутар зангидсан буюу хэмжихүй.

/Зураг 4/

- 1) “Тус үгийг Дарь эхийн тайлбартад Дад ану чандал эхийн гал буюу гэж тайлбарлав” (Хас-Эрдэнэ ба бус, 1997, т.182,183). /Зураг 5-ын дугаартай харгалзсан үсэг/
- 2) Тус үгийг Дарь эхийн тайлбарт Фати ану орой дахь дуслын урсгал буюу гэж тайлбарлав (Хас-Эрдэнэ ба бус, 1997, т.182,183).
- 3) Тус үгийг Дарь эхийн тайлбарт Чанадын заслын хүрднийг эвдэгч ану мутарын дуслыг татагч буюу хэмээн тайлбарлав (Хас-Эрдэнэ ба бус, 1997, т.182,183).
- 4) Тус үгийн доор тал хэсэг нь элэгдэж балархайшжээ. Дээд хагас хэсэг ба балархайшсан хэсгийн орон зайг үндэслэж бусад орчуулгатай харьцуулж үзээд “Баруун” гэсэн үг мөн гэж сэргээв (Хас-Эрдэнэ ба бус, 1997, т.182,183).
- 5) “Жийгсэн” гэдэг үгийг маш онцлогтой бичжээ. 1431 оны орчуулгад мөн адилаар бичиж байна. Энэ бол хоёр /i/ эгшгийг давхарлаж урт эгшиг болгосон байдаг (Хас-Эрдэнэ ба бус, 1997, т.182,183).
- 6) Тус үгийн дээд хагас дахь хэсэг нь ховхорч унажээ. Бусад орчуулгад “Машид Бадрагч” гэж байгаа нь “машид” гэсэн үг байсан болов уу гэж таамаглаж байна (Хас-Эрдэнэ ба бус, 1997, т.182,183).
- 7) Тус үгийг “Бадрагч да” гэж салгаж уншвал зохино. Энд “Бадрагч” гэсэн үгэн дээр өгөх оршихын тийн ялгалын /та/ дагаврыг шууд залгаж бичжээ (Хас-Эрдэнэ ба бус, 1997, т.182,183).
- 8) Бичээс дэх тус шадын дунд хэсэгт гагцхүү “бадрагчид” гэх үг тодорхой байж, дээд дод хэсэг нь бүр элэгдэж ховхроод унших юмгүй болжээ. Гэвч 1431 оны дөрвөн


* Үсгийн нурууны зурлагатай эгц түвшинг заана.

нийцэт модон барын сударт тус шадьг “Шатмал гал хүрэлгэгч машинд бадрагч да” гэж тэмдэглэж байх бөгөөд Колфоны орчуулгад “Шитаа малгүй гал хүрэлгэгч эх” гэж бичиж байна (Хас-Эрдэнэ ба бус, 1997, т.182,183).



Аржайн 32 дугаар агуй “Долдугаар Дарь эх чанадасыг тэмцэгчийг эвдэгчийн магтаал”-ын ханын бичээс нь нэлээд бүрэн бүтэн байгаа бөгөөд, тодорхой үйлдэгдсэн үсэг нь 10 /дагаврыг багтаана/, балархайшсан үсэг нь 11, бүрмөсөн эвдэгдэж арилсан үсэг нь 3 байна. Эдгээр үсгийг 107 үсэглэвэр болгон задлан салгаж анализ хийж, илэрхий балархайшсан буюу бүрмөсөн эвдэгдэж арилсан 9 үсгийг загварчлан сэргээв.

Аржай агуйн ханын бичээс нь хулсан үзгийн гар бичмэл байдаг учраас зурлагын хэлбэрийг барагцаалан хэмжээлэв. Үүнд, загварчлан ашиглагдах анхны “мөргөмүү”-ийн /м/-аар жишээлбэл, тус магтаал шүлэгт “М” үсэглэвэр 5 байдаг. m-5 нь /m үсэглэвэрийг зааж байна. Зураг 1-b үзүүлэв/ Үгийн эхэнд орох үсэглэвэр, бусад нь дунд орох үсэглэвэр “мөргөмүү”-ийн /м/-ийг загварчлан сэргээх хамгийн тохиромжтой үсэглэвэр болой.


Зураг 5-а



Зураг 5-б



Зураг 6



m-5-д гурван баримжаат зурлагын хэлбэрийн стандартаар анализ хийвэл: /Зураг 6/ /m-5/ -ийн орой*-н хэлбэр нь хөндлөнгөөр** барагцаалан ½ баримжаа зурлагын хэлбэрийн стандартын хэмжээтэй адил урт байж, хэлбэр нь шөвгөр байна.

/m-5/-ийн ацаг***-н хэлбэр нь хөндлөнгөөр барагцаалан нэг баримжаа зурлагын хэлбэрийн стандартын хэмжээнээс урт байж, голтоор**** барагцаалан ½ баримжаа зурлагын хэлбэрийн стандартын хэмжээнээс урт байж, хавчсан өнцөг нь нэгэн түвшинд буй. Ацгийн хошуу*****-ны хэлбэр нь хөндлөнгөөр барагцаалан ½ баримжаа зурлагын хэлбэрийн стандартын хэмжээтэй адил урт байж, гулдаар нь барагцаалвал нарийн баримжаа зурлагын

* Үсгийн зурлагын эхлэлийн нуруутай алсалсан цэгийн хэлбэр

** Үсгийн нурууны чиглэлтэй эгц чиглэлийг заана

*** Нурууны зурлага буюу номын зурлын төгсгөлөөс салаалан өмнөш татсан охор зурлагын хэлбэр

**** Үсгийн нурууны чиглэлтэй зэрэгцээ чиглэлийг заана.

***** Ацгийн нурууны зурлагад нийлэх буюу салаалан татсан битүү бус зурлагын төгсгөл цэгийн хэлбэр

хэмжээний стандартын хэмжээтэй адил, өнцөг хэмжилт нь түвшнээс дээш 30 градусаас бага, хэлбэр нь мөлгөрдүү байна.

/m-5/ -ийн гээг *****-ийн эхэн цэгийн хэлбэр нь хөндлөн гулдаар баримжаавал зурлагын хэлбэрийн стандартын хэмжээнээс охор, эхэн цэгээс дунд цэгт чиглэх хэлбэр нь хөндлөнгөөр барагцаалан нэг баримжаа зурлагын хэлбэрийн стандартын хэмжээтэй адил урт, өнцөг хэмжилт нь түвшнээс доош 30 градусаас бага байна.

Дунд цэгээс адаг цэгт чиглэх хэлбэр нь голтоор барагцаалан хоёр баримжаа зурлагын хэлбэрийн стандартын хэмжээнээс богино байж, өнцөг хэмжилт нь барагцаалан түвшингээс доош 60 градусаас их 90 градусаас бага байна.

Гээгийн хошуу* хэлбэрийг хөндлөнгөөр барагцаалбал ½ баримжаа зурлагын хэлбэрийн стандарт хэмжээнээс богино, өнцөг хэмжилт нь түвшнээс доош 30 градусаас бага, хэлбэр нь шөвгөр байна.

Адил аргаар уйгаржин монгол бичээс “Долдугаар Дарь эх чанадасыг тэмцэгчийг эвдэгчийн магтаал” үлдсэн 107 үсэглэвэр урт, өргөн, өнцөг хэмжилт зэрэгт анализ хийж, онцлогийг нь хураангуйлав. /Бусад үсэглэвэрийн анализыг энд дурдсангүй/.

Үсэглэвэрт загварчлан сэргээлт хийхэд нэг, нэг бадгаар тус бүр нэг багц болгон сэргээлт хийсэн байна. Аржай агуйн монгол бичээс нь нэг хүн бичсэн бус гэдэг нь тодорхой бөгөөд, нэг бадаг буюу хэдэн бадаг шүлгийг өөр, өөр хүн бичсэн байх магадлалтай.

“Долдугаар Дарь эх чанадасыг тэмцэгчийг эвдэгчийн магтаал”-ын үсэглэвэрт загварчлан сэргээлт хийх үсэглэвэр нь мөргөмү – М_о, эвдэгч – э_в, баруун-у_н, хураан – х_у_р_и_я, зүүн – ном зурлага, шатмал – ш_и_т_а_м_а_л, гал – г_а_л, хөрөлгөхүй – нум_ө_р_ү_л_нум_э_ном зурлага_ү_й, машид – м_а_ш_и_д зэргээр бичжээ.

Загварчлагдан ашиглагдах анхны “мөргөмү” –ийн“ м” –аар жишээлбэл: “Мөргөмү”-ийг үсэглэвэрийн зурлага хэлбэрээр задалбал “м+гэдэс зурлага+и+r+гү+m+ү” байдаг. Энэхүү үсэгт балархайшсан авиа нь “м” байж, түүнийг дахин үсэглэвэрээр задалбал оройн цэг, нуруу, ацаг, гэдэг, нуруу гэх зэрэг үсэглэвэр юм.

“Мөргөмү” үсгийн “м”-ийн сэргээлт “долдугаар Дарь эх чанадасыг тэмцэгчийг эвдэгчийн магтаал” бичээст таван “м” авиа бичсэн байж, түүн дотор зөвхөн м-5 нь дээд орох “м” авиа байж, дээрх үсэглэвэр анализ хийж хураангуйлсан онцлогтой уялдуулан м-5 –аар загварчлан сэргээв.

Бусад балархайшсан үсэг болон бүрмөсөн эвдэгдэж арилсан үсгийн үсэглэвэрийн загварчлан сэргээлтийн алхамыг энд орхив.


Сэргээлтийн хийсэн Аржай агуйн 32 дугаар агуй “Долдугаар Дарь эх чанадасыг тэмцэгчийг эвдэгчийн магтаал”-ын загварчлан сэргээсэн магтаал шүлэг нь:

“Мөргөмүү Дради хэмээгээд Фатиараар
Цагдуулын эндүүлэх хүрднийг сайтар эвдэгч
Баруун хураан зүүн жийсэн хөлөөр дарж
Шатаамал гал үйлчин маш бадарсэн эх” хэмээжээ. /Зураг 7/

***** Нурууны зурлагын ард нь дээрээс доош татсан, нурууны зурлагыг давахгүй гээг мэт зурлагын хэлбэр

* Гээгийн нурууны зурлагад нийлэх буюу салаалан татсан битүү бус зурлагын төгсгөлийн цэгийн хэлбэр

Зураг 7



ДҮГНЭЛТ

Аржай агуйн 32 дугаар агуй “Долдугаар Дарь эх чанадасыг тэмцэгчийг эвдэгчийн магтаал”-ын ханын бичээс нь нэлээд бүрэн бүтэн байгаа бөгөөд, тодорхой үйлдэгдсэн үсэг нь 10 /дагаврыг багтаана/, балархайшсан үсэг нь 11, бүрмөсөн эвдэгдэж арилсан үсэг нь 3 байна. Эдгээр үсгийг 107 үсэглэвэр болгон задлан салгаж анализ хийж, илэрхий балархайшсан буюу бүрмөсөн эвдэгдэж арилсан 9 үсгийг загварчлан сэргээв.

“Долдугаар Дарь эх чанадасыг тэмцэгчийг эвдэгчийн магтаал”-ын магтаалыг сонгодогийн өмнөх тэг зорилготой адилавар бичсэн бүрэн бичээс хараахан олдоогүй байна. Энэхүү судалгаа нь бүрэн бус бичээсийг бүрэн болгон харуулж чаджээ. Энэ нь сонгодогийн өмнөх үсгийн тэг зурлагын судлал болон дараах эхийн магтаал шүлгийн судлалын баримт ишлэлийн нэг болж чаджээ.

Монгол үсгийг загварчлан сэргээх арга нь судар ба бичээсийн шинэ чиглэлийн судалгаа болж, уг эхийг эвдэхгүйгээр сэргээлт хийх боломжтойг харуулав.

Монгол үсгийг загварчлан сэргээх арга нь хулсан үзгийн үсэг бичих онцлог журмын дагуу стандарт хэмжээ тогтоож анализ хийдгээрээ загварчлан сэргээлт хийхэд оновчтой байдаг.

Монгол үсгийг загварчлан сэргээх арга нь судар ба бичээсийн үлдэж байгаа үсгээр эвдэгдэн сүйдсэн үсгийг сэргээж үсгийн хэлбэрийг уг судар бичээстэй төсөөтэй сэргээх боломж өгч байна.

Ингэснээр түүх, соёлын эвдэгдсэн олон дурсгалыг сэргээх боломжтой болж байгаагаараа түүхийн шинжлэх ухаанд ихээхэн тус дэм өгөх нь тодорхой юм. Энэ аргаар Монгол нутгийн хадан дээрх болон агуйн доторх бичээсийг сэргээж болох юм.

Энэ чиглэлээр түүх, соёлын дурсгалын сэргээн засварлах газар санаачлага гарган түүхийн хавсарга ухааныг гүнзгийрүүлэн хөгжүүлэх шаардлага тулгарч байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Ринчен, Б. (1990). *Монгол бичгийн хэлний зүй -I*. Өвөрмонгол: Ардын хэвлэлийн хороо.

Хасэрдэнэ, Данзан, Бүрэнбат, Гарьд, Жалсан, Н.Батжаргал, Энхбаатар. *Аржай агуйн уйгаржин монгол бичээсийн судлал*. Лиюнингийн үндэсний хэвлэлийн хороо., 1997

[匈]卡拉·捷尔吉. (2004). 蒙古人的文字与书籍. 内蒙古: 内蒙古人民出版社

乔吉. (2006年05期). 1431年刊行的一部畏儿蒙文本刻版. 中国蒙古学

毕力格巴图. (2008). 关于蒙古文字合字的研究. 日本: 日本国会图书馆.

Ван Гүйрүн. (2012). *Монгол үсгийн бүтцийн судлал*. Өвөрмонгол: Лиюнингийн үндэсний хэвлэлийн хороо.

Тала, Б. (2014). Монгол үсгийн анатомиор задлан нэрийдэх аргын тухай өгүүлэх нь. *Дундад улсын монгол судлал*, р.22